



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 03 сарын 13 өдөр

Дугаар А/193

Арвайхээр сум

Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга
хэмжээг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг Захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 6 дугаар зүйл, 7 дугаар зүйлийн 7.3, 7.4 дэх заалт, Засгийн газрын 2019 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн “Мал, амьтны шилжилт хөдөлгөөнийг зохицуулах, тээвэр тууврын замд саатуулж, хорио цээрийн хяналт тавих тухай”, 43 дугаар тогтоол, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2024 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн “Мал, амьтны шимэгчтэх өвчнөөс эмчлэн сэргийлэх арга хэмжээний, төлөвлөгөө, удирдамж батлуулах тухай” А/26 дугаар тушаал, 2024 оны 02 дугаар сарын 05-ны өдрийн “Халдваргүйтгэлийн арга хэмжээг зохион байгуулах тухай” А/40 дүгээр тушаал, 2024 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн “Дархлаажуулалтын төлөвлөгөө батлах тухай” А/68 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хэмжээнд мал сүргийг халдварт, шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг 2024 оны 03 дугаар сарын 10-ны өдрөөс 10 дугаар сарын 20-ны өдрийг хүртэлх хугацаанд, “Хорогдсон мал, амьтны сэг зэмийг цуглуулж устгах, орчны цэвэрлэгээ, мал эмнэлгийн төлөвлөгөөт халдваргүйтгэл”-ийг 2024 оны 04 дүгээр сарын 10-ны өдрөөс тус тус зохион байгуулсугай.

2. Мал, амьтны гоц халдварт, халдварт өвчин гарсан тохиолдолд сумын Засаг дарга, төрийн байгууллага болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, хоорондын уялдаа холбоог сайжруулж, мэргэжлийн анги томилон ажиллах боломжоср хангах, холбогдох хууль, журам заавар, стандартыг мөрдөх, отрын бүс нутгаас буцаж ирэх, дамжин өнгөрөх малын шилжилт хөдөлгөөний үед зөвлөн туслах, хяналт тавих үүрэг бүхий хяналтын цэг ажиллуулах, мал, амьтны сэг зэмийг цуглуулж устгах, халдваргүйтгэлийн ажилд шаардагдах зардлыг шийдвэрлэж, хонь, ямааны цэцэг өвчин 10 суманд гарсантай холбогдуулан бүх бог малыг хашаа хороонд нь шүршиж угаах аргаар угаалга, халдваргүйтгэлийг хийж, тайлан мэдээг хугацаанд нь гаргаж Мал эмнэлгийн газарт ирүүлэхийг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. “Хорогдсон мал, амьтны сэг зэмийг цуглуулж устгах, орчны цэвэрлэгээ, мал эмнэлгийн төлөвлөгөөт халдваргүйтгэл”-ийн арга хэмжээний хүрээнд орчны цэвэрлэгээ, халдваргүйтгэл хийх, ажлыг тухай бүр хэрэгжүүлж, хамтран ажиллахыг аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Хүнс, хөдөө аж ахуйн газар (С.Цэдэнбалжир), Эрүүл мэндийн газар (Н.Шиваанүрдэв), Онцгой байдлын газар (дэд хурандаа Ц.Одонбаяр), цагдаагийн газар (Цагдаагийн хурандаа Г.Чимэддагва), Байгаль орчин, аялал жуулчлалын газар (Г.Баясгалан), аймгийн Автотээврийн үндэсний төвийн Өвөрхангай аймаг дахь салбарын дарга (Д.Төмөрбаатар) нарт тус тус үүрэг болгосугай.

D:My Doc. Zahiramj. Zasag darga

4.Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зарцуулагдах тарилгыг цаг хугацаанд нь татан авч, хувийн мал эмнэлэг, үйлчилгээний нэгжүүдэд хүргэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээний явц, чанар үр дүнтэй уялдуулан санхүүжилт олгох, малын шилжилт хөдөлгөөн отор нүүдэлд мал эмнэлгийн хяналт тавьж, удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Мал эмнэлгийн газар (А.Нямдаваа), хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (О.Сумъяасүрэн) нарт тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



И.ДОРЖСҮРЭН